



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/22

Арвайхээр

Дүрэм, бүтэц, орон тоо батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “б”, 29.3 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны “Чиглэл, дүрэм, бүтэц, ажлын байрны тодорхойлолт батлах тухай” А/242 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Насан туршийн боловсролын талаар баримтлах чиглэл”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Насан туршийн боловсролын төвийн дүрмийг нэгдүгээр, бүтэц, орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү захирамж батлагдан гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2013 оны “Насан туршийн боловсролын төв байгуулах тухай” а/417, 2016 оны “Төвийн дүрмийн зарим нэр томъёонд өөрчлөлт оруулах тухай” а/233 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100045

Аймгийн Засаг даргын 2020 оны 01...
дугаар сарын 27-ны өдрийн 1/22 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



АЙМГИЙН “НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ”-ИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмээр аймгийн Насан туршийн боловсролын төв /цаашид “төв” гэх/-ийн үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Аймгийн төвд бие даасан төв ажиллана.

1.3. Төв нь сумдын насан туршийн боловсролын салбар, нэгжийг /цаашид нэгж гэх/ мэдээлэл, арга зүйн удирдлагаар хангах, орон нутаг дахь насан туршийн боловсролын хөтөлбөр боловсруулж, сургалт явуулах, судалгаа хийх, төрийн болон төрийн бус байгууллага, дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг насан туршийн боловсролын хүрээнд зохицуулах, иргэдэд тасралтгүй боловсролын үйлчилгээ үзүүлэх зорилготой боловсролын сургалтын байгууллага мөн.

1.4. Төв нь энэхүү дүрэмд нийцсэн дотоод журамтай байна.

1.5. Төв нь байгууллагын тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.

Хоёр. Төвийн удирдлага, зохион байгуулалт

2.1 Төвийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж, орон нутгийн хүн амын тоо, үйл ажиллагааны цар хүрээнээс хамааран бүтэц, орон тооны хязгаарыг тогтооно.

2.2 Төв нь захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, багшийн орон тоотой байна. Захирлыг Төрийн албаны салбар зөвлөлийн сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн аймгийн Засаг дарга, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлөх ба бусад ажилтныг төвийн дарга томилж, чөлөөлнө.

2.3 Төвийн захирал, ажиллагсад нь төрийн үйлчилгээний ангиллын албан хаагч байна.

2.4 Төвийн захирлын албан тушаалын тодорхойлолтыг аймгийн Засаг дарга, бусад ажилтны албан тушаалтын тодорхойлолтыг төвийн даргын тушаалаар тус тус баталгаажуулна.

2.5 Сумын Насан туршийн боловсролын нэгжийн багш-арга зүйчийг тухайн сумын Засаг дарга томилж, чөлөөлнө.

2.6 Төвийн дэргэд орон тооны бус мэргэжлийн баг, сонирхлын бүлгэм ажиллаж болно.

2.7 Төв нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрмийг мөрдлөг болгоно.

2.8 Төвийн үйл ажиллагаа нээлттэй, хүртээмжтэй, тасралтгүй байна.

Гурав. Төвийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

3.1 Тухайн орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагуудын материаллаг бааз, боловсон хүчний нөөцийг түшиглэж, иргэдэд насан туршийн боловсрол олгох хүрээнд хамтран ажиллах;

3.2 Орон нутгийн хүн амын боловсролын түвшинг судалж, санал, дүгнэлт боловсруулан орон нутгийн засаг захиргааны байгууллагаас шийдвэр гаргуулах, хэрэгжүүлэх;

3.3 Үйл ажиллагааны хүрээнд дотоодын болон олон улсын байгууллага, иргэдтэй хамтран хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, бусад байгууллагын насан туршийн боловсролын чиглэлээр хамтарч ажиллах;

3.4 Хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, сургалт, судалгаа явуулах замаар санхүүгийн зохих нөөц бүрдүүлж, холбогдох хууль, журмын дагуу зарцуулах;

3.5 Насан туршийн боловсролын чиглэлээр сургалт-үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагаас холбогдох мэдээ, тайланг солилцож, хамтран ажиллах;

3.6 Иргэдийн хэрэгцээнд үндэслэн гэр бүл, иргэнд ёс суртахуун-төлөвшил, эрүүл мэнд, гоо зүй-мэдрэмж, эрх зүй, амьдрах ухааны болон дүйцсэн хөтөлбөрийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг орон нутагт тасралтгүй зохион байгуулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төр, иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулж зохицуулах;

3.7 Аймгийн насан туршийн боловсролын төв нь сумын нэгжийн багш-арга зүйч, бусад салбар, иргэний нийгмийн байгууллагын насан туршийн боловсролыг иргэдэд эзэмшүүлэх чиг үүрэг бүхий ажилтны мэргэжлийг дээшлүүлэх сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;


3.8 Орон нутгийн холбогдох байгууллагууд, иргэдээс насан туршийн боловсролтой холбоотой мэдээ, судалгаа авч мэдээллийн сан бүрдүүлэн, Насан туршийн боловсролын үндэсний төвийн мэдээллийн санд нэгтгэх;

3.9 Сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын нэмэлт туслах материал, гарын авлагыг сайжруулах, салбар нэгжүүдэд түгээх;

3.10 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан насан туршийн боловсролын үйлчилгээ, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах;

3.11 Үйл ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд Насан туршийн боловсролын үндэсний төв, аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх боловсрол, соёл, урлагийн газарт хүргүүлэх.

Аймгийн Засаг даргын 2020 оны 01 дугаар сарын 27-ны өдрийн 122 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



АЙМГИЙН “НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ”-ИЙН
БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаал	Тоо	Ангилал
1.	Төвийн захирал	1	ТҮБД -5
2.	Сургалтын менежер	1	ТҮБД-4
3.	Нийгмийн ажилтан	1	ТҮБД-3
4.	Багш	2	ТҮБД-3
	Бүгд	5	

-oOo-